The background of the cover features a vibrant green aurora borealis (northern lights) dancing across a dark, starry night sky. In the lower foreground, the dark silhouette of a person stands on a hill, looking up at the celestial display. The image is split diagonally from the top right corner, with a solid blue triangle above and a solid black triangle below.

**МҮҮРЬ АУДИТ ХХК-ИЙН
ИЛ ТОД БАЙДЛЫН ТАЙЛАН**
2021/10/01 – 2022/09/30 БИЗНЕСИЙН ЖИЛ



MOORE

ТАЙЛАНГИЙН АГУУЛГА

ЧАНАРЫН УДИРДЛАГЫН ТОГТОЛЦООНЫ ТАЛААРХ МЭДЭГДЭЛ	4
МҮҮРЬ АУДИТ ХХК-ИЙН ТАНИЛЦУУЛГА, ЗАСАГЛАЛ	5
Мүүр Global сүлжээний тухай	5
Мүүр Аудит ХХК-ийн танилцуулга	6
Бид хэн бэ?	6
Бидний түүх	6
Фирмийн нэр хүнд	7
Бидний амжилтууд	7
Фирмийн бүтэц	7
Мүүрийн үйлчилгээ	8
ЧАНАРЫН УДИРДЛАГА, ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО	10
Чанарын удирдлагын бодлого, горим	10
Фирмийн чанарын удирдлагын тогтолцоо	10
Гэрээт ажлын чанарын удирдлага	11
Гэрээт ажлын чанарын хяналт	12
Чанарын удирдлагын хэлтсийн мэргэжилтнүүдийн танилцуулга	13
Үйлчлүүлэгчийг хүлээн зөвшөөрөх нь	13
Аудитын чанарыг хэмжих үзүүлэлтүүд	13
Фирмд хийгдсэн хөндлөнгийн чанарын хяналт ба үр дүн	14
Аудитын чанарыг хадгалах болон сайжруулахтай холбоотой цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ	15
ХҮНИЙ НӨӨЦ БОЛОН СУРГАЛТ, ХӨГЖЛИЙН БОДЛОГО	15
Ажилд шинээр авах болон ажилтнуудыг тушаал дэвшүүлэхтэй холбоотой бодлого	15
Мүүрийн хүний нөөцийн бодлого	15
Ажилтнууддаа санал болгож буй үнэ цэн	16
Мэргэжилтнүүдийн мэдлэг, ур чадвар болон туршлага	16
Мэргэшлийн үзүүлэлтүүд	16
Голлох мэргэжилтнүүд товч танилцуулга	17
Сургалт, хөгжлийн бодлого ба хэрэгжүүлэлт	19
Сургалт, хөгжлийн бодлого	19
Онцлох сургалтын хөтөлбөр ба систем	19
Сургалтын гүйцэтгэл	19
Ажилтнуудын ажлын ачаалал, гэрээт ажлын багт шаардлагатай мэдлэг, чадвартай ажилтнуудыг хуваарилах нь	20
ЁС ЗҮЙН ЗАРЧИМ БОЛОН ХАРААТ БУС БАЙДЛЫН НИЙЦЭЛ	21
Ёс зүйн зарчим болон хараат бус байдалтай холбоотой дотоод бодлого, журам, стандарт	21
Ёс зүй ба хараат бус байдал	21
Фирмийн ёс зүйн дүрэм	21
Ёс зүйг сахиулахын тулд бид юу хийдэг вэ?	21
Ёс зүйн зөрчил ба шийдвэрлэлт	22
ҮЙЛЧЛҮҮЛЭГЧДЭДЭЭ ХҮРГЭСЭН ҮНЭ ЦЭН	22
Мүүр үйлчлүүлэгчдэдээ хэрхэн үнэ цэн хүргэдэг вэ?	22
Бизнесийн жилд үйлчлүүлэгчдийн хүртсэн үнэ цэн	22
Үйлчлүүлэгчийн сэтгэгдэл	22
Шинэ үйлчлүүлэгчийг чиглүүлэх сургалт	23
Үйлчлүүлэгчид зориулсан онлайн сургалт	23

“ Хувьсан өөрчлөгдөж буй дэлхий ертөнцөд Хөгжин дэвжихэд тань бид тусална. ”

МҮҮРЬ АУДИТ ХХК-ИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН ТАЙЛАН



**Жаргалсайханы
Ариунаа**

Мүүр Аудит ХХК-ийн
Гүйцэтгэх захирал

СЗХ-ны үнэт цаасны бүртгэлийн журам, Мүүр Аудит ХХК-ийн “Үнэт цаасны зах зээлд оролцогчдод үйлчилгээ үзүүлэх журам” болон “Мэдээллийн ил тод байдлын журам”-ын дагуу фирмийн 2021-2022 оны бизнесийн жилийн Аудитын ил тод байдлын тайланг бэлтгэн та бүхэнд толилуулж байна.

Мүүр Аудит ХХК нь аудитын ил тод байдлын тайланг анх удаа бэлтгэн олон нийтэд нээлттэй тайлагнаж байна. Энэ нь Монгол Улсын аудитын фирмүүд дундаас анх удаа ил тод байдлын тайлангаа бэлтгэн олон нийтэд мэдээлж буй гэдгээрээ онцлог юм. Аудитын фирмүүд өөрсдийн мэдээллийг олон нийтэд ил тод мэдээлснээр аудит, мэргэжлийн зөвлөх үйлчилгээний талаар бизнес эрхлэгчид, хөрөнгө оруулагчид, оролцогч талууд болон олон нийт илүү сайн ойлголттой болох, улмаар илүү оновчтой шийдвэр гаргахад эергээр нөлөөлөх ач холбогдолтой юм.

Мүүр Аудит ХХК нь үүсгэн байгуулагдсан цагаасаа эхлэн үйлчлүүлэгчдэдээ өндөр чанартай, мэргэжлийн стандартад нийцсэн үйлчилгээг хүргэж, үнэ цэн бүтээхийг зорьж ирсэн. Өдгөө 15 жилийн туршид аудит, нягтлан бодох бүртгэл, татварын зөвлөх үйлчилгээг хүргэж, мэргэжлийн салбартаа чанартай үйлчилгээгээрээ танигдсан, МУ-ын томоохон аудитын фирмүүдийн нэг болж хөгжжээ.

Та бүхэн энэхүү ил тод байдлын тайлангаас Мүүр Аудит ХХК-ийн чанарын удирдлагын тогтолцоо болон 2021-2022 оны бизнесийн жилд хийгдсэн аудитын чанартай холбоотой голлох ажлуудын мэдээлэлтэй танилцана уу!

Хүндэтгэсэн,

Ж. Ариунаа
Гүйцэтгэх захирал

2023/02/24

МҮҮРЬ ГЛОБАЛ СҮЛЖЭЭНИЙ ТУХАЙ



Энди Арманино

Мүүр Глобал Сүлжээний
удирдах зөвлөлийн
дарга

Мүүр Аудит ХХК нь дэлхийн 112 оронд тархсан 34,413 мэргэжилтэнтэй, аудит, нягтлан бодох бүртгэл, зөвлөх үйлчилгээ үзүүлдэг Мүүр Глобал Сүлжээний гишүүн фирм юм.

Мүүр Глобал сүлжээний гишүүн болон корреспондент фирмүүдийн дэлхийн нийт орлого 3.945 тэрбум ам.доллар байна. Сүлжээний гишүүнчлэл нь гишүүнчлэлийн гэрээгээр зохицуулагддаг.

Мүүрийн зорилго нь өөрсдийн ажилтнууд, үйлчлүүлэгчид болон үйл ажиллагаа явуулж буй тухайн нийгмийг цэцэглэн хөгжихөд нь туслах явдал бөгөөд үүнд манай гишүүн фирм бүр мөн хамаардаг. Манай фирмүүд нь бие даасан бизнес эрхлэгчид боловч бидний сүлжээ тэдэнд нарийн мэргэжлийн хүний нөөц, дэмжлэг, туршлага, технологийн дэмжлэг авах бүрэн боломжийг олгодог. Бидний дундын нөөц нь манай фирмүүдийг дэлхийн хэмжээний шийдлүүдийг үйлчлүүлэгчид санал болгох, бизнесийн олон салбар болон үйлчилгээний төрлүүдэд хамтран ажиллах, дараагийн үеийн удирдагчдыг хөгжүүлэх боломжийг олгодог.

Мүүр Глобалын Удирдах Зөвлөлөөс сүлжээний ойрын хоёр жилийн стратегийн төлөвлөгөө болон зорилтуудыг тодорхойлон гаргасан.

Бидний анхаарал хандуулах гол чиглэлүүд нь:

- Гишүүн фирмүүдийг нэгэн ижил үнэт зүйлсээр нэгтгэж, чанарын удирдлагын тогтолцоо, үүрэгхариуцлагыг сайжруулах, үүнд сүлжээний чанарын хяналт, сургалт хөгжүүлэлтийн хөтөлбөрүүд болон залуу удирдагчдыг хөгжүүлэхэд анхаарах гэх мэт үйл ажиллагаа багтаж байгаа юм.
- Тодорхой, ойлгомжтой, төвлөрсөн бизнес зорилтуудаар дамжуулан дэлхийн түвшинд өргөжин тэлэх стратегийг хэрэгжүүлэх.
- Хийж буй бүх зүйлсдээ чанарыг түгээх.
- Гишүүн фирмүүдэд технологи нэвтрүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх зорилгоор инновацад төвлөрөх.
- Хамтын ажиллагаа, харилцаа холбоо, ил тод байдлын тусламжтайгаар гишүүн фирмүүдэд хүргэх үнэ цэнийг нэмэгдүүлэх.
- Манай сүлжээний стратеги болох Social Ambition хөтөлбөрөөр дамжуулан нийгэмд эерэг нөлөө үзүүлэх.


МҮҮРЬ АУДИТ ХХК-ИЙН ТАНИЛЦУУЛГА

БИД ХЭН БЭ?

Үнэ цэнд чиглэсэн, шинэлэг үйлчилгээгээр дамжуулан өөрийн үйлчлүүлэгчдийг санхүү бүртгэлийн үйл ажиллагаагаа олон улсын түвшинд хүргэх, бизнесийн боломжуудыг ашиглаж, эрсдэлээс сэргийлж, цахим шилжилтийг нэвтрүүлэхэд нь туслах замаар тэдний бизнесийг хөгжин дэвжихэд нь найдвартай зөвлөх туслагч байна.



БИДНИЙ ТҮҮХ




ФИРМИЙН НЭР ХҮНД

Мүүрь Аудит ХХК нь МУ-ын томоохон аудитын фирмүүдийн нэг юм. ММНБИ-ээс жил бүр борлуулалтын орлогын үзүүлэлтээр Монгол Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй бүх аудитын фирмүүдийг эрэмбэлж, тэргүүлсэн фирмүүдийг олон нийтэд зарладаг. Мүүрь Аудит ХХК нь 2021 оны Борлуулалтын орлогын дүнгээр Монгол Улсад 7-р байранд эрэмбэлэгдсэн.

БИДНИЙ АМЖИЛТУУД

- МҮХАҮТ-ээс 2018 **АУДИТЫН САЛБАРЫН ЭНТЕРПРЕНЕР**-аар шалгаруулсан.
- ММНБИ-ээс 2018 **ОНЫ ОНЦЛОХ АУДИТЫН КОМПАНИ**-аар шалгаруулсан.
- ММНБИ-ээс 2019 **ОНЫ АЖЛЫН БАЙРНЫ ӨСӨЛТТЭЙ АУДИТЫН КОМПАНИ**-аар шалгаруулсан.
- ММНБИ-ээс Баталгаажуулах үйлчилгээний Ахлах менежер П. Нарантуяаг 2021 **ОНЫ ШИЛДЭГ АУДИТОР**-аар шалгаруулсан.
- МУ-ын Төрийн Аудитын байгууллагаас 2021 оны санхүүгийн тайлангийн аудитыг чанартай гүйцэтгэсэн **ШИЛДЭГ АУДИТЫН КОМПАНИ**-аар шалгаруулж, Ерөнхий аудиторын өргөмжлөл авсан.

ФИРМИЙН БҮТЭЦ (ХУРААНГУЙЛСАН):





МҮҮРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

Манай фирм нь дараах үйлчилгээг үйлчлүүлэгч нартаа санал болгодог:

БАТАЛГААЖУУЛАХ ҮЙЛЧИЛГЭЭ

- **Санхүүгийн тайлангийн аудит**
 - Нийтлэг зориулалттай тусдаа санхүүгийн тайлангийн аудит
 - Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудит
 - Завсрын нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудит
- **Санхүүгийн тайланг нягтлах ажил**
 - Санхүүгийн тайланг нягтлах гэрээт ажил
 - Завсрын үеийн санхүүгийн мэдээллийг нягтлах гэрээт ажил
- **Бусад баталгаажуулах ажил**
 - Санхүүгийн тайлангийн бүрэлдэхүүн хэсгийн баталгаажуулалт
 - Санхүүгийн тайланд холбогдох мэдээллийн баталгаажуулалт

ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ

- **Нягтлан бодох бүртгэл, татварын зөвлөх үйлчилгээ**
 - НББ-ийн бодлогын бичиг баримт боловсруулалт, зөвлөгөө
 - СТОУС, НББОУС, үндэсний стандартын зөвлөгөө
 - Татварын зөвлөх үйлчилгээ
 - Нягтлан бодох бүртгэл хөтлөлтийн аутсорсингийн үйлчилгээ
 - НББ, татварын сургалт

• Үнэ шилжилтийн үйлчилгээ

- Үнэ шилжилтийн тайлан бэлтгэх, орчуулах
- Үнэ шилжилтийн зөвлөгөө өгөх
- Бэнчмарк бэлтгэх
- Дотоод үнэ шилжилтийн онлайн сургалт

• Корпорацийн санхүүгийн үйлчилгээ

- Хөрөнгийн зах зээлийн үйлчилгээ (IPO, нэмэлт хувьцаа гаргах болон хувьцаа гаргасны дараах үйлчилгээнүүд)
- Санхүүгийн Due Diligence
- Санхүүжилт, хөрөнгө босголтын зөвлөх
- Бизнесийн нэгдэлт, худалдан авалт болон борлуулалтын зөвлөгөө
- Бизнесийн үнэлгээ хийхэд туслалцаа үзүүлэх, зөвлөх

ЗАСАГЛАЛ, ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА, ДОТООД ХЯНАЛТЫН ҮЙЛЧИЛГЭЭ

- Үйл ажиллагааны аудит
- Санхүүгийн аудит
- Нийцлийн аудит
- Мөнгөний үнэ цэнийн аудит

Бид дараах төрлийн дотоод аудитын аутсорсингийн үйлчилгээг (үйл ажиллагааны, санхүүгийн, нийцлийн болон мөнгөний үнэ цэнийн аудит) хүргэдэг:

- Бүрэн аутсорсинг (Full outsourcing)
- Хэсэгчилсэн аутсорсинг (Partial outsourcing)
- Хамтарсан (Co-sourcing)
- Туслах гэрээ (Subcontracting)

ЧАНАРЫН УДИРДЛАГЫН БОДЛОГО, ГОРИМ

Манай фирмийн чанарын удирдлагын тогтолцооны суурь нь дараах баримт бичгүүд болон стандартууд болно:

- ЧУОУС 1, ЧУОУС 2, АОУС 220
- Дотоодын хууль эрх зүйн шаардлагууд
- Мүүрь Глобалын чанарын удирдлагын тогтолцооны бодлого, горимууд

Фирмийн чанарын удирдлагын тогтолцоо нь фирмийн түвшинд болон гэрээт ажлын түвшинд загварчлагдсан бөгөөд зураглан харуулвал:



ЧУОУС 1-н бүрэлдэхүүн хэсэг бүрээр бодлогууд, авч хэрэгжүүлэх горимуудыг тусгасан байдаг.

Мөн Мүүрь Глобал сүлжээний дотоод хяналтын бодлогын дагуу 3 жил тутамд фирмийн чанарын удирдлагын тогтолцоог үнэлдэг. ЧУОУС 1-н дагуу фирм нь өөрийнхөө чанарын удирдлагын тогтолцоог хамгийн багадаа жилд 1 удаа үнэлж шаардлагатай сайжруулалтыг хийдэг.

Монгол улсын хууль, дүрэм, журамд заасны дагуу Сангийн Яам, Санхүүгийн Зохицуулах Хороо, Үндэсний Аудитын Газраас фирмийн чанарын удирдлагын тогтолцоог тогтмол үнэлдэг.

Аливаа зохицуулагч байгууллагын, сүлжээний чанарын хяналт эсвэл дотоод мониторингийн үнэлгээний дараа Root cause analysis буюу илрүүлсэн зүйлсийн үндэслэл, шалтгааныг тайлбарласан шинжилгээ хийдэг бөгөөд түүнд үндэслэн чанарын удирдлагын тогтолцоо болон гэрээт ажлын гүйцэтгэлтэй холбоотой хийж сайжруулах ажлын төлөвлөгөөг гарган хэрэгжүүлж ажилладаг.

ГЭРЭЭТ АЖЛЫН ЧАНАРЫН УДИРДЛАГА

Аудитын гэрээт ажлыг олон улсын стандартад нийцүүлэн, өндөр түвшний чанартай хийж гүйцэтгэхийн тулд Фирм аудитын олон улсын стандарт, сүлжээний аудитын гарын авлага, дотоодын хууль дүрэм журмуудад үндэслэн фирмийн аудитын эрсдэлд суурилсан гарын авлагыг боловсруулан мөрдөж ажилладаг. Тус аудитын гарын авлага нь сэдэв бүрээр нарийвчилсан заавар, загвар ажлын баримтууд бүхий нийт 4 дэвтэр, 32 бүлэг, 1007 (сүүлийн хувилбар) хуудастай бөгөөд холбогдох стандарт, дүрэм журам өөрчлөгдөх бүрд шаардлагатай шинэчлэлт сайжруулалтыг хийдэг. Аудитын ажлыг гүйцэтгэхэд Мүүрь Глобал сүлжээний түүврийн хэмжээ тогтоогч, материаллаг тогтоогч зэрэг төрөл бүрийн хэрэгслийг ашигладаг бөгөөд аудитын ажлын удирдлага, эрсдэлийн үнэлгээ, дата анализ, үйлчлүүлэгчтэй харилцах зэрэгт дэлхийн нягтлан бодогчдын холбоогоор хүлээн зөвшөөрөгдсөн хиймэл оюун ухаанд суурилсан олон улсын программ хангамжийг ашиглаж байна.

Аудитын үндсэн гарын авлагаас гадна үнэт

цаасны зах зээлд оролцогчдод үйлчилгээ үзүүлэхдээ баримталдаг Үнэт заасны зах зээлд оролцогчдод үйлчилгээ үзүүлэх тусгайлсан гарын авлагыг зохицуулагч байгууллагын шаардлагын дагуу боловсруулан мөрдөж ажиллаж байна.

Чанарын удирдлагын тогтолцооны болон гэрээт ажлын түвшинд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаанд оролцох, түүнтэй холбоотой бусад эрсдэлээс ангид байх хүрээнд Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй (МУТС) тэмцэхэд чиглэсэн фирмийн дотоод хяналтын хөтөлбөрийг 2020 онд баталсан. Тус хөтөлбөрийн хүрээнд МУТС эрсдэлийн үнэлгээ хийх, хөтөлбөрийн хэрэгжилтэд мониторинг хийх ажлууд тогтмол хийгдэж байна. МУТС эрсдэлээс сэргийлэхэд зориулан үйлчлүүлэгчийн аливаа хууль бус үйл ажиллагаанд оролцсон, шүүхээс ял шийтгэл, хариуцлага хүлээсэн эсэх эсвэл улс төрд нөлөө бүхий этгээдтэй холбоотой эсэхийг тогтоохын тулд НҮБ-н хориг жагсаалт, Монгол улсын Авлигатай тэмцэх газрын нээлттэй мэдээллийн сан, шүүхийн шийдвэрийн нээлттэй мэдээллийн сан, Refinitiv олон улсын санхүүгийн дата, дэд бүтцийн үйлчилгээ үзүүлэгч компанийн Worldcheck one системд хайлт хийх зэрэг горимуудыг хэрэгжүүлдэг.

Аудитын гэрээт ажилд чанарын удирдлагыг дараах түвшинд хэрэгжүүлдэг бөгөөд тус бүртээ фирмийн дотоод стандартуудын нийцэл, АОУС, Чанарын удирдлагын стандартууд, СТОУС (холбогдох СТ-н хүрээ) болон бусад холбогдох хууль, дүрэм, журмын нийцлийг шалгана:

- Менежерийн / аудиторын хяналт
- Гэрээт ажлын захирлын хяналт
- Гэрээт ажлын чанарын шалгагчийн хяналт (EQCR)

Дээрх хяналтуудыг хийх явцад хяналтын түвшин бүрд гэрээт ажил бүрээр тухайн ажилтны гүйцэтгэсэн ажлыг 1-5 оноогоор үнэлдэг бөгөөд тухайн ажилтны нийт гүйцэтгэсэн ажлын дундаж үнэлгээ нь жилийн гүйцэтгэлийн үнэлгээнд чухал нөлөө үзүүлж тухайн ажилтан албан тушаал ахих, урамшуулал авах зэрэгт суурь үзүүлэлт болдог. Гэрээт ажлын үнэлгээг Сэжент мэргэжлийн үйлчилгээний удирдлагын системд гэрээт ажил бүрийн төгсгөлд хийдэг.



Чанарын хяналтын үнэлгээ нь тухайн ажилтны гүйцэтгэлийн үнэлгээ болон урамшуулалд дараах байдлаар нөлөөлдөг:

КРІ, хувь хүний гүйцэтгэлийн үнэлгээ	ЧХ-ын оноо нь албан тушаалаас шалтгаалан тухайн ажилтны гүйцэтгэлийн үнэлгээний 30 хувийг эзэлдэг. Гүйцэтгэлийн үнэлгээний үр дүн нь тухайн ажилтны албан тушаал ахих болон фирмээс олгож буй боломжуудыг хүртэх гол шалгуур болдог.
ЧХ-ын оноо ажилтны урамшуулал	Гүйцэтгэлийн урамшуулал олгоход гэрээт ажлын ЧХ-ын оноог харгалзан үздэг. Зөвхөн ЧХ-ын хангалттай болон түүнээс дээш үнэлгээ авсан гэрээт ажлын багт урамшуулал олгогддог.

ГЭРЭЭТ АЖЛЫН ЧАНАРЫН ХЯНАЛТ

Фирмийн чанарын хяналтын дотоод стандартын дагуу дараах гэрээт ажлуудын хувьд тайлан дүгнэлт нь гарахаас өмнө чанарын хяналт хийхийг шаарддаг. Чанарын шалгагч нь аудитын явцад оролцохгүйгээр аудитын баг болон үйлчлүүлэгчээс хараат бус байх, ёс зүйтэй, хангалттай мэргэжлийн туршлага ур чадвартай байх гэсэн шалгууруудыг хангасан байна.

Гэрээт ажлын чанарын хяналт зайлшгүй хийгдэх гэрээт ажлын төрлүүд:

- Төрийн өмчит болон олон нийтийн сонирхолтой аж ахуйн нэгжүүд (хөрөнгийн биржид бүртгэлтэй болон бүртгүүлэхээр хүсэлт гаргасан аж ахуйн нэгжүүдийг хамруулаад)
- Тусгай зохицуулалттай этгээдүүд (Банк, ББСБ-ууд, Брокер диллерийн пүүсүүд, Хөрөнгө оруулалтын сангууд г.м)
- Бусад нарийн төвөгтэй болон өндөр эрсдэлтэй гэж тодорхойлсон аж ахуйн нэгжүүд

ЧАНАРЫН УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТНҮҮДИЙН ТАНИЛЦУУЛГА



Н. ГЭРЭЛЧИМЭГ
Чанарын хяналтын менежер

Боловсрол: НББ бакалавр (СЭЗИС), Актуарын магистр (Мармарагийн их сургууль, БНТУ)

Туршлага: 9 жил



З. ДАЙРИЙМАА
Чанарын хяналтын менежер

Боловсрол: НББ бакалавр (Мандах ИС, СЭЗИС)
Мэргэжлийн зэрэг: МНБ, Аудитор

Туршлага: 8 жил

ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙГ ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨХ НЬ

Фирмийн шинэ үйлчлүүлэгчийг хүлээн зөвшөөрөх болон хуучин үйлчлүүлэгчид үйлчилгээг үргэлжлүүлэн хүргэх эсэх талаарх бодлого, горимуудыг Чанарын хяналтын дотоод стандарт, Аудитын дотоод стандартад тус тус тусгасан бөгөөд тус процессийг Сэжент мэргэжлийн үйлчилгээний удирдлагын системээр дамжуулан гүйцэтгэдэг. Үйлчлүүлэгчийг хүлээн зөвшөөрөх, харилцааг үргэлжлүүлэхдээ фирмийн бодлого, горимуудын дагуу дараах хүчин зүйлсийг харгалзан үздэг:



Фирмийн үйлчлүүлэгчийг хүлээн зөвшөөрөх бодлогын дагуу 2021-2022 оны бизнесийн жилийн нийт хүлээн авсан үйлчилгээний хүсэлтийн 43 хувьд үйлчилгээний санал өгөх шийдвэр гаргаж, үлдсэн 57 хувийн хүсэлтэд дээрх хүчин зүйлсийг харгалзан татгалзсан.

АУДИТЫН ЧАНАРЫГ ХЭМЖИХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Тайлант онд нийт гүйцэтгэсэн ажлуудын 23 хувьд чанарын шалгалт хийсэн бөгөөд дундаж үнэлгээ нь 3.18 буюу шаардлагад нийцсэн гэсэн үнэлгээтэй байна. Гэрээт ажлын чанарын шалгагч нь гэрээт ажлын явцад үүссэн асуудлуудыг хяналт хийж, аудитын тайлан дүгнэлт гарахаас өмнө засуулж хянасан бөгөөд Фирмийн түвшинд нийтлэг ажиглагдсан сул талууд цаашид сайжруулах зөвлөмжийг жилийн гүйцэтгэлийн үнэлгээний уулзалтын үеэр нийт ажилчдад танилцуулсан.

Фирмийн чанарын удирдлагын тогтолцоо болон гэрээт ажлын чанарыг үнэлэх зорилготой дотоод мониторингийг чанарын удирдлагын хэлтсээс тайлант оны хувьд хийж гүйцэтгэсэн бөгөөд чанарын удирдлагын тогтолцоо “хангалттай”, гэрээт ажлын хувьд “үр дүнтэй” буюу “багахан хэмжээний сайжруулалт шаардлагатай” гэсэн үнэлгээ авсан.

ФИРМД ХИЙГДСЭН ХӨНДЛӨНГИЙН ЧАНАРЫН ХЯНАЛТ БА ҮР ДҮН

Тайлант онд манай фирмийн үйл ажиллагаанд сүлжээний чанарын хяналт буюу Мүүрь Глобалын чанарын хяналт, Сангийн Яамны чанарын хяналт, Үндэсний Аудитын Газрын чанарын хяналт тус тус хийгдсэн бөгөөд үр дүн нь дараах байдалтай байна.



МҮҮРЬ ГЛОБАЛ СҮЛЖЭЭНИЙ ЧАНАРЫН ХЯНАЛТ	САНГИЙН ЯАМНЫ ЧАНАРЫН ШАЛГАЛТ	ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ЧАНАРЫН ШАЛГАЛТ
<p>Хамрах цар хүрээ: Фирмийн тогтолцоо ба Баталгаажуулах гэрээт ажлууд</p> <p>Удирдамж: Мүүрь Глобал сүлжээний баталгаажуулах үйлчилгээ үзүүлж буй гишүүн фирмүүдийн мэргэжлийн стандартын мэдэгдэл, IESBA code, ISA ба ISQC 1</p> <p>Зорилго:</p> <ul style="list-style-type: none"> • Байгууллагын түвшний ЧХ-ын тогтолцоог үнэлэх; ба • Гэрээт ажлын түвшинд чанарыг үнэлэх. <p>Үр дүн:</p> <ul style="list-style-type: none"> • Чанарын хяналтын тогтолцоо - Хангалттай • Гэрээт ажлын гүйцэтгэл - Томоохон сул тал байхгүй 	<p>Хамрах цар хүрээ: Фирмийн тогтолцоо ба Баталгаажуулах гэрээт ажлууд</p> <p>Удирдамж: Сангийн сайдын 2019 оны 60-р тушаалаар батлагдсан Аудитын хуулийн этгээдэд хийх чанарын хяналтын журам</p> <p>Зорилго:</p> <ul style="list-style-type: none"> • Аудитын тухай хуулийн мөрдөлтийг үнэлэх; • Байгууллагын түвшний ЧХ-ын тогтолцоог үнэлэх; ба • Гэрээт ажлын түвшинд чанарыг үнэлэх. <p>Үр дүн:</p> <ul style="list-style-type: none"> • Хуулийн нийцэл - Нийцсэн • Чанарын хяналтын тогтолцоо - Хангалттай • Гэрээт ажлын гүйцэтгэл - 99-100% 	<p>Хамрах цар хүрээ: УАГ-ын гэрээгээр гүйцэтгэсэн аудит</p> <p>Удирдамж: АДБОУС 1000-1810, УАГ-ын чанарын баталгаажуулалтын журам, гарын авлага</p> <p>Зорилго:</p> <ul style="list-style-type: none"> • Гэрээгээр СТА-ыг хийхдээ Төрийн аудитын байгууллагаас баталсан стандарт, журам, заавар, аргачлалыг мөрдлөг болгосон эсэх; болон • Аудитын чанарын хяналтын тогтолцоо нь үр дүнтэй зохион байгуулагдсан эсэхийг тус тус тодорхойлох. <p>Үр дүн:</p> <ul style="list-style-type: none"> • Чанарын хяналтын тогтолцоо-Нийцсэн • Гэрээт ажлын гүйцэтгэл-Нийцсэн

АУДИТЫН ЧАНАРЫГ ХАДГАЛАХ БОЛОН САЙЖРУУЛАХТАЙ ХОЛБООТОЙ ЦААШИД АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

2022 оны 12 дугаар сарын 15-ны өдрөөс хэрэгжиж эхэлсэн Чанарын удирдлагын стандартуудыг Фирмийн түвшинд 2022 оны эцэст амжилттай нэвтрүүлж дууссан бөгөөд энэ ажлын хүрээнд Фирмийн түвшний эрсдэлийн үнэлгээ хийж тэдгээр эрсдэлүүдэд үзүүлэх хариу үйлдлүүдийг боловсруулсан. Энэхүү ажлуудыг Мүүрь Глобал сүлжээний Moore quality management платформын тусламжтайгаар хийсэн бөгөөд цаашид улирал бүр эрсдэлийн үнэлгээг шинэчилж хариу үйлдлүүд нь үнэлсэн эрсдэлийг удирдахуйц буюу хангалттай эсэхийг авч үзнэ.

Шинэчлэгдсэн чанарын удирдлагын стандартууд нь аудитын фирмүүдийг эрсдэл тохиолдсоны дараа хянаж шалгах уламжлалт тогтолцооноос илүүтэй эрсдэлийг урьдчилан харж үнэлж, тэдгээрт хариу үйлдэл үзүүлэх замаар эрсдэлүүдийг удирдахыг шаардаж байгаа юм. Мөн аудитын гэрээт ажлын чанарыг дээшлүүлэх, үр ашгийг нэмэгдүүлэх зорилгоор Мүүрь Глобал сүлжээний нэгдсэн программ хангамж болох Caseware олон улсын программыг хэрэгжүүлэх ажлын бэлтгэл ханган ажиллаж байна.

ХҮНИЙ НӨӨЦ БОЛОН СУРГАЛТ, ХӨГЖЛИЙН БОДЛОГО

АЖИЛД ШИНЭЭР АВАХ БОЛОН АЖИЛТНУУДЫГ ТУШААЛ ДЭВШҮҮЛЭХТЭЙ ХОЛБООТОЙ БОДЛОГО

МҮҮРИЙН ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГО:

Ажилд авах, хадгалах

Бид ажиллах хүсэл эрмэлзэлтэй, ажлын гүйцэтгэл өндөртэй хүмүүсийг авч ажиллуулдаг бөгөөд энэхүү чадварлаг нөөцийг өндрөөр үнэлж, цаашид улам сайжруулахын тулд мэргэжлийн хөгжлийн асуудлууд болон манлайлал удирдлагын чадварыг дээшлүүлэхэд онцгойлон анхаардаг.

Сургалт ба мэргэжлийн хөгжил

Бид ажилтнуудынхаа техникийн мэдлэг, чадварыг үргэлж шинэчилж тасралтгүй хөгжин дэвшихэд нь дэмжлэг үзүүлдэг. Мөн сургалт болон гүнзгийрсэн судалгаа хийж буй ажилтнуудаа бүрэн дэмжиж ажилладаг.

Дэвшүүлэх бодлого

Манай фирм ажилтны карьер, амжилтыг нэмэгдүүлэх боломжийг үргэлж олгож байдаг.

- Ажилтнуудыг ур чадвар, ажлын гүйцэтгэлд тулгуурлан албан тушаал ахиулах, карьерын төлөвлөлт хийх г.м

Хүний нөөцөд тавигдах гол шалгуур:



АЖИЛТНУУДАА САНАЛ БОЛГОЖ БУЙ ҮНЭ ЦЭН:

Боломжууд	Хэрэгжүүлэлт
Тасралтгүй суралцаж, хөгжих боломж:	
Олон улсын, Монголын болон Дотоод сургалт	2021-2022 бизнесийн жилийн нэг ажилтанд ногдох дундаж сургалтын цаг - 102 ак.цаг
Ажилтан бүрд тохируулан карьер төлөвлөлт, хэрэгжүүлэлт	CPA, ACCA цол авахад дэмжих хөтөлбөр – Шалгалтын хураамж, Цалинтай чөлөө, Гишүүнчлэлийн төлбөр
Олон улсын түвшинд ажиллах боломж:	
Туршлага хуримтлуулах	<ul style="list-style-type: none"> International engagements X-bOoster хөтөлбөр
Шилдэг аргачлалаас суралцах	<ul style="list-style-type: none"> Дэлхийн түвшний үйлчилгээний стандарт, аргачлал, ноу-хау Мүүрийн ажилтнууд мэргэжлээрээ ОУ-ын түвшинд ажиллахад бэлтгэгддэг.
Ажилтан солилцооны хөтөлбөрт хамрагдах	<ul style="list-style-type: none"> Мүүрү Глобалын ажилтан солилцоо болон шилжин ажиллах хөтөлбөр
Өрсөлдөхүйц цалин урамшуулал:	
Гүйцэтгэлд суурилсан урамшуулал	<ul style="list-style-type: none"> Гэрээт ажлын ашгийн түвшний зорилтыг биелүүлж чадвал урамшуулал авдаг.
Голлох ажилтны тэтгэмж	<ul style="list-style-type: none"> Орон сууц худалдан авах урьдчилгаа г.м
Ажил, амьдралын тэнцвэрийг хадгалах боломж:	
Ажлын ачаалал өндөр биш	<ul style="list-style-type: none"> 2021-2022 бизнесийн жилийн дундаж ажлын цаг 8.17 цаг
Ажил, амьдралын тэнцвэрийг хадгалахад чиглэсэн бодлого хэрэгжүүлдэг.	<ul style="list-style-type: none"> Ажлын уян хатан нөхцөл Зайнаас ажиллах, тохируулсан хуваарийн дагуу ажиллах боломж

МЭРГЭЖИЛТНҮҮДИЙН МЭДЛЭГ, УР ЧАДВАР БОЛОН ТУРШЛАГА

МЭРГЭШЛИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД


Олон улсын түвшний чанартай, үнэ цэнтэй үйлчилгээ үзүүлэх нь Мүүрийн үнэт зүйл учраас бид баталгаажуулалт, зөвлөх үйлчилгээний багуудаа санхүүгийн хууль тогтоомж болон бизнесийн салбаруудын туршлагад нэвтэрсэн шилдэг, олон жилийн ажлын туршлагатай мэргэжилтнүүдээр бүрдүүлэн үйл ажиллагаагаа явуулдаг билээ.

Фирм нь бизнесийн жилд 30 орчим мэргэжлийн ажилтантай үйл ажиллагаа явуулсан ба тэдгээрийн мэргэжлийн үзүүлэлтийг харваас (2022 оны 9-р сарын байдлаар):

“ Бид өндөр чанартай, найдвартай санхүүгийн үйлчилгээ нь тухайн ажлыг гүйцэтгэж буй багийн чадавхид оршдог гэдэгт итгэдэг. ”


Мэргэшсэн нягтлан бодогч
40% (12 хүн)


Зөвшөөрөлтэй аудитор
30% (9 хүн)


Магистрын зэрэг
20% (6 хүн)


Татварын итгэмжлэгдсэн нягтлан бодогч
20% (6 хүн)

ГОЛЛОХ МЭРГЭЖИЛТНҮҮД ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Манай фирм нь Баталгаажуулах үйлчилгээ, Зөвлөх үйлчилгээ болон Засаглал, эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын үйлчилгээ гэсэн 3 гол хэлтсээр дамжуулан мэргэжлийн үйлчилгээг үзүүлдэг. Эдгээр үйлчилгээг хүргэж буй менежерүүд болон багууд маань тухайлсан үйлчилгээгээрээ дагнан мэргэшиж, туршлага хуримтлуулсан байдаг учраас үйлчлүүлэгчид илүү үнэ цэн хүргэж чаддаг.

Манай голлох мэргэжилтнүүдийн (захирал, менежерүүд) товч мэдээлэлтэй танилцана уу.



У. ОЮУНАА
Мэргэжлийн үйлчилгээ хариуцсан захирал

Боловсрол: НББ бакалавр, Бизнесийн удирдлагын магистр
Мэргэжлийн зэрэг: МНБ, ТМЗ, Аудитор, Татварын шинжээч
Туршлага: 36 жил
Шагнал: МОНГОЛ УЛСЫН ШИЛДЭГ ТАТВАРЫН ЗӨВЛӨХ (ТМЗН, 2010 он)



Н. МЯГМАРЖАВ
Мэргэжлийн үйлчилгээ хариуцсан захирал

Боловсрол: НББ бакалавр, Бизнесийн удирдлагын магистр, Олон улсын худалдааны магистр (Macquarie University)
Мэргэжлийн зэрэг: МНБ, ТМЗ, Аудитор,
Туршлага: 26 жил



Ж. АРИУНАА
Гүйцэтгэх захирал

Боловсрол: НББ бакалавр, Бизнесийн удирдлагын магистр (INTI International University), Менежментийн ухааны магистр (University of Hertfordshire)
МЭРГЭЖЛИЙН ЗЭРЭГ: МНБ, ТМЗ, Аудитор
ТУРШЛАГА: 13 жил

Баталгаажуулах үйлчилгээний хэлтэс:



П. НАРАНТУЯА
Баталгаажуулах үйлчилгээний ахлах менежер

Боловсрол: НББ бакалавр
Мэргэжлийн зэрэг: МНБ, Аудитор
Туршлага: 25 жил
2021 оны ШИЛДЭГ АУДИТОР (ММНБИ)



Н. ДАГИЙРАГЧАА
Баталгаажуулах үйлчилгээний ахлах менежер

Боловсрол: НББ бакалавр
Мэргэжлийн зэрэг: МНБ, ТМЗ, Аудитор
Туршлага: 17 жил

Засаглал, эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын үйлчилгээний хэлтэс



Б. МЯДАГМАА
Засаглал, эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын үйлчилгээний менежер

Боловсрол: НББ бакалавр, Бизнесийн удирдлагын магистр
Мэргэжлийн зэрэг: МНБ, Аудитор
Туршлага: 14 жил



БРАЙН ХЭЙС
Засаглал, эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын үйлчилгээний зөвлөх

Боловсрол: Эрх зүйн бакалавр, University College Cork
Мэргэжлийн зэрэг: CMI-IA by Chartered Institute of Internal Auditors Chartered Accountants Ireland
Мэргэжлийн туршлага: 22 жил

Зөвлөх үйлчилгээний хэлтэс



М. МӨНХЦЭЦЭГ
НББ, татварын зөвлөх үйлчилгээний ахлах менежер

Боловсрол: НББ бакалавр
Мэргэжлийн зэрэг: МНБ, ТМЗ, Аудитор, Татварын шинжээч
Туршлага: 20 жил
Шагнал: МОНГОЛ УЛСЫН ШИЛДЭГ ТАТВАРЫН ЗӨВЛӨХ (ТМЗН, 2014 он)



ЭНТОНИ ХЕЙЛИ
Үнэ шилжилтийн үйлчилгээний ахлагч

Боловсрол: Хууль зүйн бакалавр
Мэргэжлийн зэрэг: МНБ (Австрали)
Туршлага: 20 жил



Н. ГЭРЭЛЧИМЭГ
Корпорацийн санхүүгийн үйлчилгээний менежер

Боловсрол: НББ бакалавр, Актуарын магистр
Туршлага: 9 жил

СУРГАЛТ, ХӨГЖЛИЙН БОДЛОГО БА ХЭРЭГЖҮҮЛЭЛТ

СУРГАЛТ, ХӨГЖЛИЙН БОДЛОГО

Бид АОУС, ЧУОУС, МУ-ын аудитын тухай хууль, Мэргэшсэн нягтлан бодогчийн ёс зүйн дүрэм, Мэргэшсэн нягтлан бодогчдын тасралтгүй боловсролын сургалтын журам, компанийн Аудитын дотоод стандарт, Чанарын хяналтын дотоод стандарт, Ёс зүйн дүрмийг тус тус үндэслэн Мүүрь Аудит ХХК-ийн “Сургалт хөгжлийн журам”-ыг 2020 онд шинэчлэн баталсан.

Ажилчдын тухайн жилд хамрагдах сургалт хөгжлийн үйл ажиллагааг ажилтан тус бүрийн сургалтын хэрэгцээ шаардлага, аудитын үйл ажиллагаанд ашиглагддаг хууль журам, стандартын өөрчлөлт, цаг үеийн болоод улс орны нөхцөл байдалд тулгуурлан боловсруулсан тухайн бизнесийн жилийн сургалтын төлөвлөгөөгөөр зохицуулдаг.

1 бизнесийн жилд хангах ёстой сургалтын цагийн шаардлага

- Партнер болон гүйцэтгэх захирал 70 кр цаг
- Мэргэжлийн үйлчилгээний менежер 70 кр цаг
- Мэргэжлийн үйлчилгээний туслах 50 кр цаг
- Аудитор, мэргэжилтэн, зөвлөх 60 кр цаг

ОНЦЛОХ СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР БА СИСТЕМ

- Фирмийн ажилтнууд хоорондоо мэргэжлийн ажлын туршлагаа солилцох, бие биенээсээ суралцаж туршлага хуримтлуулах, карьерын өсөлтийг дэмжихэд чиглэсэн X-bOOster хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлдэг. Уг хөтөлбөрийн хүрээнд энэ бизнесийн жилд нийт 8 удаагийн сургалт дотооддоо зохион байгуулсан байна.
- Фирм нь ажилтнууддаа тасралтгүй сурч хөгжих боломжоор хангах, үйлчлүүлэгчдэдээ илүү үнэ цэн хүргэх зорилгоор онлайн сургалтын платформыг үйл ажиллагаандаа ашигладаг.



СУРГАЛТЫН ГҮЙЦЭТГЭЛ

Бизнесийн жилийн гүйцэтгэлээр фирмийн ажилчид нийт 3200 кредит цагийн сургалт, хөгжлийн үйл ажиллагаанд хамрагдсан бөгөөд энэ нь нийт ажилласан цагийн 5 хувийг эзэлж байна.

Фирмийн түвшинд бизнесийн жилийн сургалтын төлөвлөгөөний биелэлтийн хувь 184% байна.

АЖИЛТНУУДЫНАЖЛЫНАЧААЛАЛ,ГЭРЭЭТАЖЛЫНБАГТШААРДЛАГАТАЙ МЭДЛЭГ, ЧАДВАРТАЙ АЖИЛТНУУДЫГ ХУВААРИЛАХ НЬ

Гэрээт ажилд мэргэжлийн ажилтныг томилоход бид дараах зүйлсийг харгалзан үздэг. Үүнд: Аудитын багийн гишүүн нь:

- Цаг хугацааны хувьд тухайн гэрээт ажил дээр ажиллах боломжтой эсэх
- Мэдлэг, ур чадвар хүрэх эсэх
- Багийн гишүүд нь тухайн төрлийн ажлыг гүйцэтгэсэн хангалттай туршлагатай эсэх
- Хараат бусаар ажиллаж чадах эсэх
- Ёс зүйн болон мэргэжлийн стандартын бусад шаардлагыг хангаж буй эсэх

Аудитын гэрээт ажлын багийн бүрэлдэхүүн нь дараах албан тушаалтнуудаас бүрддэг.



Бизнесийн жилийн аудитын багийн ачаалал, ба гэрээт ажлын дундаж цаг зарцуулалтын мэдээлэл:



ЁС ЗҮЙН ЗАРЧИМ БОЛОН ХАРААТ БУС БАЙДЛЫН НИЙЦЭЛ

ЁС ЗҮЙН ЗАРЧИМ БОЛОН ХАРААТ БУС БАЙДАЛТАЙ ХОЛБООТОЙ ДОТООД БОДЛОГО, ЖУРАМ, СТАНДАРТ

ЁС ЗҮЙ БА ХАРААТ БУС БАЙДАЛ

Бидний баримталдаг бодлого, үйл ажиллагаа Монголын Мэргэшсэн Нягтлан Бодогчдын Институтийн зүгээс тавигдах шаардлага болон Олон улсын нягтлан бодогчдын холбооны шаардлагуудад бүрэн нийцдэг.

Манай байгууллагад ёс зүйн нийцлийг хангахад чиглэсэн ажилтнуудад зориулсан сургалт хөгжлийн үйл ажиллагаа зохион байгуулдаг. Мөн ажлын явцад хийгдэх сургалтаар мэргэжлийн ёс зүйтэй холбоотой байгууллагын бодлого, үйл ажиллагаа зэргийг тогтмол заадаг бөгөөд холбогдох дүрэм, журамд өөрчлөлт орох бүрд энэ талаар бүх ажилтнуудад сургалт явуулдаг.

Бид дотооддоо болон Мүүрь Глобал сүлжээний бусад гишүүн фирмүүдтэй хамтран ажиллахдаа үйлчлүүлэгч бүрд үзүүлсэн үйлчилгээний цар хүрээний талаар бүртгэж, шинэчилж байдаг нэгдсэн бүртгэлийн механизмын ажиллагааг хангаж, тухайн гэрээт ажил нь манай фирмийн хараат бус байдалд хэрхэн нөлөөлөх нөлөөллийг үнэлж чаддаг.

Компани нь өөрийн бүх аудиторууд, ажилтнуудаас хараат бус байдлын шаардлагыг бүрэн хэмжээнд даган мөрдөж байгаа талаар баталгаа гаргуулан авдаг бөгөөд үүнийг жил тутамд шинэчилдэг. Бүх ажилтнууд нь хориглосон хөрөнгө оруулалтын мэдээллийн сантай заавал танилцах журамтай бөгөөд энэхүү мэдээллийн санд олон нийтэд нээлттэй хувьцаа арилжаалж буй үйлчлүүлэгч нарын мэдээлэл байдаг.

Компанийн хараат бус байдлыг ханган ажиллах процессыг жил тутам эргэн хянаж, үнэлж байдаг бөгөөд хамаарах хууль, тогтоомжтой бүрэн нийцүүлдэг.

ФИРМИЙН ЁС ЗҮЙН ДҮРЭМ

Мүүрь Аудит ХХК нь байгууллагын эрхэм зорилго, үнэт зүйлсдээ тулгуурлан бизнесийн үйл ажиллагаа явуулахад баримтлах ёс зүйн дүрмийг дотооддоо боловсруулан баталсан бөгөөд байгууллагын бүх ажилтан, ажиллагсад энэхүү дүрмийг чандлан мөрдөж ажилладаг. Манай компанийн Ёс зүйн дүрэм нь байгууллагын ажиллагсад мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах ёс зүйн зарчмыг тодорхойлоод зогсохгүй тэдэнд харилцагчид, хамтран ажиллагсад, бизнесийн бусад оролцогч талууд, болон олон нийт, нийгэмтэй хэрхэн харилцах гэх мэт өргөн хүрээний харилцааны ёс зүйн болон зан суртахууны хэм хэмжээг тодорхойлж өгдөг юм.

ЁС ЗҮЙГ САХИУЛАХЫН ТУЛД БИД ЮУ ХИЙДЭГ ВЭ?



ЁС ЗҮЙН ЗӨРЧИЛ БА ШИЙДВЭРЛЭЛТ

2021-2022 оны бизнесийн жилд ёс зүйн зөрчил болон гомдол гараагүй.

ҮЙЛЧЛҮҮЛЭГЧДЭДЭЭ ХҮРГЭСЭН ҮНЭ ЦЭН


МҮҮРЬ ҮЙЛЧЛҮҮЛЭГЧДЭДЭЭ ХЭРХЭН ҮНЭ ЦЭН ХҮРГЭДЭГ ВЭ?


 1. ҮЙЛЧИЛГЭЭ	БИД ЯМАР ҮНЭ ЦЭН ХҮРГЭДЭГ ВЭ? <ul style="list-style-type: none">• Үйлчлүүлэгчид тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэхэд туслах• Чанартай үйлчилгээ• Үйлчилгээгээ цагтаа үзүүлж, ажлын үр дүнг амласан хугацаандаа хүргэх• Хэрэгтэй, хэрэгжүүлж болохуйц зөвлөгөө• Нэр хүндийн баталгаа• Найдвартай байдал
 2. ЗӨВЛӨГӨӨ	
 3. СУРГАЛТ	
 4. ҮЙЛ АЖИЛЛАГАА	


БИЗНЕСИЙН ЖИЛД ҮЙЛЧЛҮҮЛЭГЧДЭД ХҮРГЭСЭН ҮНЭ ЦЭН


ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙН СЭТГЭГДЭЛ:

2021-2022 оны бизнесийн жилийн үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн судалгааны үр дүнгээс оруулав.

 Эзэмшсэн мэргэжилдээ эзэн байхаас гадна зөв хандлага харилцаатай, хүлээцтэй, мэргэжлийн ёс зүйтэй байсан нь манай хамтран ажилласан ажилтнуудад том нөлөөг үзүүлсэн. Аудитын багийн мэргэжлийн ур чадвар үнэхээр сайн байсан нь манай компанийн ня-бо болон санхүүгийн ажилтануудад эерэг нөлөөг үзүүллээ

 Хяналтаа сайжруулах цэгүүдийг тодорхойлоход бодитой зөвлөмж өгсөн.

 Итгэл, дараа жилийн үйл ажиллагаагаа итгэл төгс явуулах эрх чөлөөг манай байгууллагад өгсөн.

 Санхүүгийн үйл ажиллагаанд зөвлөгөө дэмжлэг үзүүлсэн, санхүүгийн тайлангийн толилуулгыг зөв оновчтой болгож өгсөн төдийгүй байгууллагын дотоод үйл ажиллагааг сайжруулахад нөлөөлсөн.

ШИНЭ ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙГ ЧИГЛҮҮЛЭХ СУРГАЛТ:

Анх удаа аудит хийлгэж буй болон олон улсын аудитыг анх удаа хийлгэж буй тохиолдолд аудитын талаарх суурь ойлголт өгөх, талуудын аудитын явцад хүлээх үүрэг, хариуцлагыг тодорхой болгосноор талуудын оролцоог хангах, үйлчлүүлэгч байгууллагадаа илүү их үнэ цэн хүртэх боломж олгох, аудитыг илүү үр ашигтай гүйцэтгүүлэхэд чиглэсэн чиглүүлэх сургалтыг фирмийн чанарын удирдлагын хэлтсээс хийдэг. 2021-2022 оны бизнесийн жилд хүсэлт гаргасан бүх шинэ үйлчлүүлэгчид уг сургалтыг хийж, дэмжиж ажилласан.

ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИД ЗОРИУЛСАН ОНЛАЙН СУРГАЛТ:

Мүүрийн зөвлөх, мэргэжилтнүүд нь өөрийн үйлчлүүлэгч байгууллагын удирдлага, нягтлан бодогч, санхүүгийн болон бусад ажилтнуудад үнэ цэн хүргэх үүднээс төрөл бүрийн онлайн сургалтын контентыг бэлтгэн хүргэдэг. 2021-2022 оны бизнесийн жилд үйлчлүүлэгч байгууллагуудын онлайн сургалтад хамрагдсан байдлыг сургалтын чиглэлээр ангилан харуулав (давхардсан тоогоор).



Холбоо барих

Монгол улс, Улаанбаатар хот 14240
Сүхбаатар дүүрэг, 1-р хороо
Олимпын гудамж 7/3, Центрум төв
7 давхар, 701 тоот
Утас: +976 7015 0003
И-мэйл: info@moore-mongolia.mn



www.moore-mongolia.mn

Энэхүү материалыг хэвлэн нийтлэх үед үүнд агуулагдсан мэдээлэл нь үнэн зөв гэдэгт бид итгэлтэй байна. Гэхдээ уг мэдээлэлд үндэслэсэн үйлдэхүй, эс үйлдэхүйгээс шалтгаалан аливаа этгээдэд учирсан аливаа хохирлыг бид хариуцахгүй болно. Уг материалыг Монгол Улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан Мүүрь Аудит ХХК хэвлэн нийтлэв. Мүүрь Аудит ХХК нь Мүүрь Глобал олон улсын сүлжээний гишүүн фирм юм. Мүүрь Глобал олон улсын сүлжээ болон гишүүн фирмүүд нь бүгд тус тусдаа хуулийн этгээдүүд болно. Мүүрь Глобал олон улсын сүлжээ болон гишүүн фирмүүд нь толгой компани, охин компани, нөхөрлөл, хамтарсан үйлдвэр эсвэл агентын харилцаагүй бөгөөд ийм харилцаатай мэтээр ойлгогдох ёсгүй юм. Мүүрь Глобал сүлжээний аль ч гишүүн фирм нь Мүүрь Глобал Нэтворк Лимитэд болон сүлжээний гишүүн эсвэл корресфодент фирмүүдэд ямар ч хэлбэрийн үүрэг, хамтын хариуцлага хүлээлгэх эрхгүй (шууд, далд утгаар эсвэл бусад хэлбэрээр).